

Наранцэцэг Д.

ВАНГИЙН ЦАГААН УУЛЫН САНГИЙН СУДАРТ ХИЙСЭН ЗАРИМ ШИНЖЛЭЛ

В статье рассмотрен текст почитания горы Хулд-ула, более известной как Вангийн Цаган-ула, расположенной в 170 км на юго-запад от сомонного центра Халха-Гол в Восточном аймаке. Исторически данная территория относилась к владениям Илдэн цзюн-вана, прадеда То-вана (халхаского Токтохо-тура). Вплоть до 1930-х гг. прошлого века население Илдэн дзасак хошуна ежегодно почитали ее, а с 1990 г. данная традиция возродилась и ныне раз в три года проходит обряд поклонения. Как следует из текста поклонения хозяин-сабдак горы Цаган-ула имел обеты убашаи или гэнэна.

Автором проанализированы три варианта текстов поклонения, выделена основная структура сочинений: призывание божеств и хозяев местности, поднесение пожертвований, просьба-обращение, прощение о покровительстве, заключение. Отмечены изящность изложения, поэтичность форм, подчеркнуто, что данные тексты почитания помимо религиозного предназначения, являются прекрасными образцами монгольской литературы.

Ключевые слова: тексты воскурений, Цаган-ула, тибетоязычная литература

Narantsetseg D.

TEXTS OF INCENSE OFFERING TO THE WANGIIN TSAGAN-UL:

RESEARCH AND ANALYSIS OF TEXT

In article the text of honoring the Mount Huld-ul known also as Wangiin Tsagan-ul, which is located in 170 km to the southwest from the center of Khalkha-Gol sum of the Dornod aimak is looked upon. Historically this territory belonged to Ilden Jun Wang, the great-grandfather of To-van (khalkha Toktokhorur). Up to the 1930-ies of the last century this mount has been worshiped annually by the population of Ilden dzasag khoshu, and since 1990 this tradition was revived and nowadays every three years a worship ceremony goes on. As it is seen from the text of worship, the lord-savdak of the mountain Tsagan-ul had the vows of an ubashi or a genen.

The author has analyzed three versions of texts of worship. She revealed their main structure: invocation of deities and owners of the area, making donations, requests, prayers for protection, the conclusion. Fine narrating of the text,

the poetry of forms are noted. It is emphasized that these texts of honoring besides religious mission, are fine samples of the Mongolian literature.

Key words: texts of incense offering, Tsagan-ul, literature in the Tibetan language

Уул ус, гал тахилгын зан үйл, түүний гарал үүслийн тухайд XIX зууны үеийн нэртэй түүхч, гавж Зава Дамдин¹-ы хорчойнжүн буюу «Алтан дэвтэр»²-г: «...Бас Согдууд наран шингэх зүгээс гарсан маанийн шашин хэмээгч нэгнийг дэлгэрүүлсэн. Өдгөө маанийн шашны ёсон хаана ч үгүй боловч Монголчуудын уул тахих хийгээд гал тахих мэт нь тэр шашны үлдэгдэл мөн мэт болой³...» [Зава Дамдин, 22a] хэмээн тэмдэглэсэн байна.

Маанийн шашин гэдэг нь Маань (Mani)-ийн үүтгэсэн шашин бөгөөд Маани бээр⁴ Бага Ази, Дундад Ази, Энэтхэг, Төвд ба бас бусад орнуудаар хүрч шашнаа дэлгэрүүлж⁵ байлаа гэдэг [Хишигтогтох, 2011: 133].

¹ Ухааны таван орны их бандида Шагдарын Дамдин гавж (1867–1937) 17 боть зохиолтой.

² ‘dzam glin byang phogs chen po’i hor gyi rgyal khams kyi rtogs pa brjod pa’i bstan bcos chen po dpyod ldan mgu byed ngo mtshar gser gyi debt her zhes bya ba bzhugs so. 22a.

³ Т: yang sog thag dag gis nyi ma nub phoygs nas byung ba’i ma na’ya’i chos lugs zer bag cig rgyas par mzad do. Deng sang ma na’ya’i chos lugs ni gang na’ang ma lab mod, ‘on kyan mon gol gyi ri mchod dang me mchod lta bu ni chos de’i lhag ma yin ‘dra’o.

⁴ Тэрбээр нийтийн он тооллын 216 онд Бабилуны нэгэн жижиг тосгонд төрсөн, 25 насандаа маанийн шашныг үүтгэсэн. Ираны Sasinian хаант улсын хаан Sharur I (?-272) эхлээд тус шашныг дэмжиж байгаад сүүлд нь 276 онд Маанийг баривчлан гянданд хорьсон тул тэндээ таалал болсон гэдэг.

⁵ Маанийн шашин Иранаас барууншаа Сири, Египет, Умард Африк, Ром, Gallia-ийн өмнө бие, Испани зэрэг газарт зүүншээ Дундад Азийн улс орнуудад дэлгэрчээ. Ялангуяа Уйгурчууд төрийн шашнаа болгож байв. 694 онд Хятадад нэвтрэн орсон бөгөөд баруун орны уйгурчуудын дэмжлэг доор Дундад оронд хүчтэй дэлгэрч, олон газар маанийн шашны сүм хийд байгуулагдан «Да Юнь гэгээн гэрэлт сүм» (大云光明寺) гэж нэрлэгдэж байжээ. Маанийн шашинд «Хоёр аймаг судар (гэгээн болон харанхуй)» (二

Тэрчлэн «Магадасанмо-гийн онол өгүүлэл» хэмээх зохиолд: «Магадасанмо бээр Бурмын мод аривжих⁶ хэмээх бурханы шашин дэлгэрээдүй аглаг хязгаар орноо бэр болон очоод, олон тэрсүүдээс уйсан гашуудаж бурханыг тахирын тул байшингийнхаа дээвэр дээр гаран сангийн утааг уул мэт уугиулсан нь Ялж төгс нөгчсөн бурханы оршин ахуй Шравасди⁷ балгаснаа тахилын уул болж харагдсан түүхтэй холбоотой юм» [Чоймаа нар, 1999: 201-202] гэх буюу Тисрондэвзан хааны үед Төвд орны догшин газрын эзэд хилэгнэн хаан хийгээд хамаг газар нутаг даяарт амгалангүй болсонд их тарнич ловон Бадмажунай⁸-г урин залж, газар усны эздийг номхотгуулав [Санжай, 1993: 123-124]. Түүгээр Төвдөд анх овоо тахиx, уул ус, лус савдаг, газрын эздийг тахиx зан үйл гарсан гэдэг бөгөөд Монгол оронд ловон Бадмажунайн зохиосон «Нолсан лхачав онмо»⁹ тэргүүтэн сангийн олон судар ихэд дэлгэрчээ. Эдгээрийг эш үндэс болговол гал тахилга, уул усны сан тайлгын зан үйл Энэтхэг, Төвдөөр дамжин Монголд уламжлагдсан ч байж болох талтай.

Нүүдэлчин удамтай Монголчуудын хувьд эрт дээр цагаас ган зуд, гай турхан зэрэг байгалийн хатуу ширүүн үзэгдлийг хариулахын тулд нутаглан суугаа газар усаа юуны өмнө аргадан, сан сэржим уншин, сайн идээ шүүс өргөн, санаа бодлоо даатган соёрхол эрдэг ёс бий. Монгол оронд тахиж тайж ирсэн газар усны тоо 800 орчим байгаа бөгөөд эдгээрийн ихэнх нь сан тахилгын судартай байв [Сүхбаатар, 2001: 16]. Үүний нэг нь Дорнод Монголын алдарт Вангийн Цагаан уулын сангийн судар юм. Цагаан

宗经)), «Гурван цагийн судар (өнгөрсөн, одоо, ирээдүй)» (三际经) гэх сонгодог ном байдаг гэж хятад сурвалж бичигт тэмдэглэсэн буй. Үнэхээр XIX зууны сүүлчээр Дүн хуан, Шинжианаас тус шашны номын тасархай олджээ [Хишигтогтох, 2011: 133].

⁶ Т: bu ram shing 'phel.

⁷ Т: gnyan yod.

⁸ Т: pad ma 'byun gnas. Үржан орны Данагаша хэмээх нуурын лянхуа цэцгээс хувилж төрсөн тул Лянхуагаас мэндэлсэн орон буюу Бадмажунай хэмээн алдаршжээ. Нууц тарнийн ниммава ёсыг үндэслэгч. Монгол оронд ловон Бадмажунайн зохиосон олон сангийн судар дэлгэрчээ.

⁹ Т: mnol bsang lha chab sngon mo.

уул хэмээх энэхүү тахилгат уул нь Дорнод аймгийн Халхгол сумын нутагт сумын төвөөс баруун урагш 170 км зайтай, Сангийн далайн зүүн урд байдаг, Хулд уул ч хэмээн нэрлэх [Аким нар, 2009: 121] бөгөөд далайн төвшинөөс 1099 м өргөгдсөн, улсын хилээс дотогш 36 км зайтай орших, их талын дунд 40–60 км алсаас бараа нь харагдах, уулын орой дээрээс бол 30–50 км-ын газрын бараа энгийн нүдээр харагдах цэрэг, стратегийн нэн чухал байрлалтай нутаг болно [Сүхбаатар, 2011: 31]. Энэ уул Халхын Тогтохтор тайж буюу То вангийн дээд өвөг Илдэн жүн вангийн үеэс тэдний эзэмшил нутаг байсан тул ардууд Вангийн Цагаан уул гэж нэрлэж заншжээ. Цагаан уулыг 1930-аад оныг хүртэл Илдэн засаг хошууныхан жил бүр тахиж байсан бол 1990 оноос тахилга тайлгыг сэргээн, 3 жил тутамд нэг удаа тахиж болжээ.

Монголчууд хүндэтгэн биширч ирсэн уул усандаа бөө мөргөлийн шашин хүчтэй хөгжиж байсан үед уул хайрханыг Хан, ус голыг Хатан хэмээн өргөмжлөн нэрлэж байсан бол шарын шашин хүчтэй дэлгэрснээс хойш Богд, Хайрхан нэрийг уулын нэрд дагуулах буюу газар зүйн онцлог хэв шинж, дүр байдлын өвөрмөц чанарыг харгалзан газар шинчээчийн өгсөн нэрээр төвд, монголоор нэрлэх хандлага их байжээ. Цагаан уул хэмээсэн нь Монголчууд тахилгат уулаа хүндэтгэн дээдлэх үүднээс уугуул нэрийг бүтэн дуудахыг цээрлэн, харагдах байдлаар нь Цагаан уул хэмээн нэрлэсэн ч байж болно. Юутай ч уулын эзэн шивдаг нь их увш буюу гэнэн сахилтай байжээ гэдгийг бид энэ сангийн судраас харж болно. Ер нь Монголчууд уулын эзэн савдаг нь цол зэргэмтэй, сахил санваартай хэмээн сэтгэж өргөмж нэр хайрлаж байсан уламжлал өргөн бий. Үүний жишээ нь бидний сайн мэдэх Зайсан толгой, Цэцээ гүн юм.

Бидэнд энэ Цагаан уулын сангийн судрын төвд гар бичмэл эхээс гадна дууч Жүрмэдийн Далхаагийн монгол бичгээс кирилл үсэгт буулгасан хувилбар, үүнээс академич П. Хорлоо гуайн монгол бичгээр бичсэн сийрүүлэг, доктор О. Сүхбаатар гуайн төвд хэлнээс орчуулсан ийм гурван зүйл орчуулгын зохиол олоод байна. Орчуулга хэмээсний учир нь бид энэ судрыг анх төвд хэлээр, Төвдийн «цэгжэд» хэмээн нэрлэдэг манай мэргэд, эрдэмтэй лам нарын зохиол бүтээлээ туурвиж ирсэн шүлэглэх хэлбэрээр бичигдсэн зохиол, үүнийг үе үеийн хүмүүс өөр өөрийн арга

зарчмаар орчуулж иржээ гэж үзэж байгаа бөгөөд Ж. Далхаа гуайн хөрвүүлж, П. Хорлоо академичийн сийрүүлсэн хувилбар нь судрын хэлний уламжлалт орчуулгыг баримталсан гэж болохоор үгчилсэн орчуулга байгаа бол доктор О. Сүхбаатар гуай төвд эхэд шүлэглэх зарчмаар бичсэн бол түүнийг утга дагуу толгой сүүл холбон, шүлэглэн орчуулдаг тэрхүү аргаар орчуулсан байна.

Зохиолын бүтцийн хувьд бурхан бодьсатва, орны эзэн тэргүүтэн дөрвөн зүйл зочдыг урин залсан урилга заллагын хэсэг, бодтой тахил өргөлийн хэсэг, өчил, даатгал залбирлын хэсэг, төгсгөлийн үг гэсэн үндсэн бүтэцтэй бөгөөд тахил, даатгал, ариулах зан үйл үйлдсэний дараа тус тусад нь эгээрэл хүслийг илэрхийлэн залбирал ерөөл тавьсан байна.

Үүнд урилга заллагын хэсэгт:

Сайн оюут Чадагчийн эрхэт

Сац бас их Очирдара тэргүүтэн

Язгуур үндэсний дээд лам

Ядам чухаг дээд гурав

хэмээн орны ялгалыг үл харгалзан алин орны сан тавих зан үйл адил байдгийн ёсоор өөрт үсэг зааснаас эхлээд номын үндэс номлосон, авшиг хайрласан, увдис соёрхсон лам багш нар, Тантарын дөрвөн аймгийн Ядам бурхад, Бурхан багш, ойрын найман шавь, арван зургаан батад агч, Язгуурын таван бурхан, сайн цагийн мянган бурхад сэлтийг «Хүндлэлийн зочид»-оор урин залжээ. Залгаад:

Номын сахиулсан дагинас хийгээд

Нот үнэн ари нар

хэмээн гурван орны баатар, дагинас тэргүүтэн номыг тэтгэгч сахиусдын чуулгад сэлтийг «Итгэл эрдэмийн зочид» болгон залаад, зургаан зүйл амьтан, жил, сар, хоногийн тэнгэр, орны тэнгэр, дэлхийн эзэд тэргүүтнийг «Нигүүлсэхүйн зочин» болгохын ёсоор:

Халхын голын баруун зүгийн их жавхлант

Хан цагаан уулын оройд орисон

Буяны садны санваар бүхий

Оюу үснэрт цагаан хүмүүн

Буй гурван орныг эрхэндээ хураахын

Улаан хиурыг баруунаа барьж

Бусдад хэрэгтэй үйлс бүхэн гарах

*Сангийн хулгана зүүнээ барьсан
Бууршгүй хүчит ажнай хөлөглөж
Орон газрыг өмнөө сахьсан
Жолоо цулбуурыг барин залсан
Өндөр хөх азар тэргүүтэн
Өмөг садан нөхдийн чуулган
Өдгөө энэ орноо ажрагтун*

хэмээн энэ уулын эзний байдал төрхийг Халхын голын баруун зүгт байдаг сүр жавхлан төгөлдөр Цагаан уулын орой дээр оршсон, оройн үснэр дундаа охиу эрдэнийн чимэгтэй, лагшины өнгө нь цагаан, баруун мутартаа гурван орныг¹⁰ эрхэндээ хураахын бэлгэдэл болсон хиур, зүүн мутартаа хэрэглэх хүсэл бүхнийг хангагч сант морин хулгана барьсан, ажнай сайн шарга морь хөлөглөн, өндөр хөх азар тэргүүтэн нөхөд дагуулаа дагуулсан гэж гадаад дүрийг тоочиж, дотоод эрдмийг дурдан дүрсэлж урин залж байна. Үүний дараагаар:

*Баян-Ухаа, Түмэнцогт хийгээд
Баяндэлгэр овоо тэргүүтэн
Энэ орноо эзэгнэн оршсон
Энгүй дэлгэр чуулган, найман аймаг
Эрхэт цагаан зүгийн тэнгэр
Эзэн шивдаг, лус, нөхөд сэлт
Рид хувилгаанаар дүрвэлгүй
Энэ орноо ажрагтун*

хэмээн тахилгат Цагаан уул, цаашилбал тахилгатай уул даваа бүхэн овоотой байдаг тул түүний ойр орчих Баян-Ухаа, Түмэнцогт, Баяндэлгэр овоо тэргүүтнийг эзэгнэн оршсон лус найман аймаг, савдаг, навдаг, шивдаг нөхөд сэлтийг урин залсны дараагаар тотгорын язгуур найман мянга, адын язгуур гурван зуун жар тэргүүтнийг «Өр төлөөсний зочид»¹¹ болгон, эдгээр дөрвөн зүйл зочдыг номын агаараас урин залаад,

*Ул одон өөрөө бүтсэн энэ дээд оронд
Үзэсгэлэн төгс эрдэнээр байгуулсан тавцанд
Үлэмж баясгалангийн мөшилзөхүй нигуураар*

¹⁰ Т: 'dod kham, gsugs kham, gsugs med kham буюу амармагийн орон, дүрстий орон, дүрс үгүйн орон.

¹¹ Т: lan chags kyi mgon.

Үсэд батаар заларч хайрла

хэмээн өөрөө бүтсэн дээд сайн орон энэ уулнаа бэлтгэн зассан үзэсгэлэнт тавцан суудалд залрахыг таалан болгоо гэсэн батад орших даншиг¹² өргөж байна.

Ингээд газарт бууж ирсэн уулын эзэн савдгийг улам баясгахын тул балин тахил, сан ариусгал өргөөд хэрэг үйлсээ даатгах, хишиг буяны даллага авах, өлзий хутгийн үгийг өгүүлэх бодтой тахил өргөлийн хэсэгт:

Ил бодтой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан

Их чуулган, балин, зохилдохуй дээд зай

Эмийн дээж, сүү, цай лугаа найруулсан

Эрдэмт таван хүсэл төгс сэржимийн далай үүгээр

Энэ шивдаг, их уви, нөхрийг тахимуй

хэмээн бодитой бэлтгэж сэтгэлээр хувилгасан тахил, өнгө үзэмж, үнэр амт төгс балин, гавар зандан тэргүүтэн сан тахилгын эд зай, олон зүйлийн эм болоод гурван цагаан¹³, гурван амттан¹⁴ тэргүүтэн сэржмийг дээд жаргалант орны бурхан бодьсад, тэнгэрийн орны гоо дагинас, номын сахиулсан, уул овооны эзэн савдагт тахил өргөх ёсыг сударт өгүүлж байна. Эдгээрээс төлөөлөл болгож «Таван хүслийн эрдэм»-ийн үүднээс өргөсөн сэржим буюу эрдэмт таван хүсэл төгөлдөр сэржим гэж чухам юуныг хэлж байгааг тайлбарлавал: бурхан тэнгэр нарын мэлмий, сонор, үнэрийн эрхтэн, зарлиг, лагшинд таван тахилын өргөл болгон эрдэнийн их дээд биндэрьяа тэргүүтэн өнгө дүрсний чуулганыг төлөөлүүлэн дүрсийн хүсэл эрдмийн¹⁵ бэлгэдэл болгож тэнгэрийн дагшин орны дүрс хөрөг хольцолдолгүйгээр ургах машид тунгалаг толийг, тэнгэрийн дууч охин Гандарийн эгшиг, өндгөн дотроо яруу дуугаар жиргэн донгодогч галабинга шувууны эгшиг тэргүүтэн дууны чуулганыг төлөөлүүлэн дууны хүсэл эрдмийн¹⁶ бэлгэдэл болгож олон чавхдаст бийбаа хөгжмийг, гавар, агар, задь, дээд сайн эмийн үнэрт хурын ус тэргүүтэн сайтар найруулсан үнэртний чуулганыг төлөөлүүлэн

¹² T: brtan bzhugs.

¹³ T: dkar gsum буюу сүү, тараг, тос.

¹⁴ T: mngar gsum буюу бурам, мөсөн чихэр, бал.

¹⁵ S: rūpakāmaguna, T: gzugs kyī 'dod yon.

¹⁶ S: śaptak, T: sgra'i 'dod yon.

үнэрийн хүсэл эрдмийн¹⁷ бэлгэдэл болгож номын дунгийн доторхи үнэрт рашаан ус, биеийг амгуулагч зургаан амт төгөлдөр, зуун амт төгөлдөр, рашааны цог төгөлдөр идээ тэргүүтэн амтатны чуулганыг төлөөлүүлэн амтын хүсэл эрдмийн¹⁸ бэлгэдэл болгон нүүрийн идээний савыг, биед хүрэлцэх төдийгөөр амгалан өгөгч тэнгэрийн цаглахуй санааны хувцас торго тэргүүтэн хүртэхүйн чуулганыг төлөөлүүлэн хүртэхүйн хүсэл эрдмийн бэлгэдэл¹⁹ болгож хөнгөн, нимгэн, зөөлөн тэнгэрийн хувцас торго энэ тавыг чимэг болгон өргөж, авралд нь багтахын төлөөнөө ерөөл тавьдаг байна.

Ялгуулсан төр, долоон зүйл эрдэнэ

Ялгуугч өлзий хутгийн найман тэмдэг

Эрдэнэ морь, сарлаг, тэмээ, хонь, ямаа

Эгээрэл хүслийг хангагч үнээ

Сүр сүлдэт хуяг дуулга

Зэр зэвсэг, баатадын чимэг

Сүмбэр уулын дөрвөн тив

Наран саран, галбарвасун мод

Сав шим хотол чуулган бүгдийн

Сайн хишгийг ирүүлж хайрла

Тахилын чуулган үүгээр эрхтэн дэлгэрээд

Та бидний санасан хэргийг бүтээн зохиогтун

гэж «Хаан төрийн долоон эрдэнэ» гэж нэрлэдэг алтан хүрд, биндэръяа эрдэнийн хөхөмдөг өнгөт чандмань эрдэнэ, дүрс бие гуа үзэсгэлэнт хатан эрдэнэ, номын хийгээд ертөнцийн үйл хэрэгт мэргэн түшмэл эрдэнэ, элдэв эрдэнэсээр чимэглэсэн заан эрдэнэ, хурдлахын ид хав төгс морь эрдэнэ, эр зориг, хүч чадал төгөлдөр баатар эрдэнийг өргөнө. Түүнчлэн Бурхан багш бээр өлзий хутгийн тахил болгон адистидласан гэдэг найман тахил болоод сэтгэл үндсийг ариусгах толь, өвчин зовлонг дарах эм гиван, нисванис амирлахыг бэлгэдсэн «Тараг», нас уртсахын өлзий хутагд адистидласан «Дүрваа өвс», буян дэлгэрэхийн өлзий хутаг гарахад адистидласан модны жимс «Билба», эш, онол дэлгэрэхийн өлзий хутаг гарах зөвшөөргүү эргэсэн «Цагаан лавай», дээдийн номоор шавийг эрхэнд хураахын өлзий хутаг гарах «Лити», хатуу үйлсийг

¹⁷ S: gandhekāmaguna, T: dri'i 'dod yon.

¹⁸ S: rasakāmaguna, T: ro'i ;dod yon.

¹⁹ S: sparśakāmaguna, T: reg bya'i 'dod yon.

бүтээхийн өлзий хутаг гарах «Гич будаа» зэрэг «Өлзийт найман эд»-ийг өргөдгийг хэлсэн байна.

*Сайхан үнэрт хүжийн зүйлийг
Газар баригч мянган тоотны чуулганы
Шатаан уугиулсан утаан үүлээр
Сансар огторгуйн орныг дүүргэж
Дэлхийн эзэн шивдаг, их уви
Дээрхийн нөхөд сэлтийг ариулмуу
Ариулснаар түйдсэн азар бузар
Аль юу бөгөөс ариун болтугай*

хэмээн урин залж авчирсан Гэнэн чэнбо уулын эзэн, нөхөр сэлтийг сангийн утаа, сайхан үнэрт хүж тэргүүтнээр тахин ариулах бөгөөд ариулснаар түйдсэн бузар юу буй бөгөөс түлбэрэлгүй сайтар арилах болтугай хэмээн залбирал тавьжээ.

*Урвах сэвэх, зарлиг зөрчих-амарлингуй болоод
Ундуу хилэн, атаа хорслыг бүү зохио
Хүссэн хэрэг сэтгэлчлэн бүтэхийн
Хүй их үйлийг зохиогтун
Энэ орны шивдаг, эзэн нөхөд сэлт
Элбэрүү цагаан зүгийн сахиулсан энэрч өршөө*

*Чинад дайсны аймгийн өмөг чуулганыг
Чанд эгээрэл хэрэглэхүй төгөлдөр үйлсийг зохируул
Орон гэрт өлзий хутаг оршуулж
Олз олдвор дэлгэрүүл, насан уртасга
Аян замын хавцгай, гол уснаас
Аяндаа гэтэлгэх тусыг бүтээ
Аюумшигт газар, дайсан хулгай
Аливаа дээрмийн хөнөөлөөс авар
Товчилбоос санасан хүссэн хэргийг
Тохицуулж сэтгэлчлэн бүтээн зохиогтун
Эгнэгт бас бус их уви, нөхөд сэлт
Эдийн тэнгэр, сангийн эзэн таалан эрхиээн соёрх*

*Язгуур, үндэс, ном төр
Ялан дэлгэрэхийн шидийг соёрх
Энэ орон машид гарсан аймгууд*

*Эрхин шагшаабадыг ариул
Эгэл гэргийтэн тэргүүтнийг ч
Энгүй дээр төрөлхтний байдлаар байлга
Аль буй эзэд ноёдууд бээр
Албат иргэдээ номын ёсоор тэтгэ
Ахуй их хотол чуулганыг
Абишид нэгдэн цэнгэхүйд энэр
Товчилбоос, дэлхийн эзэд, хайрхан нөхөд
Товлож өдөр харуул, шөнө манаа болон
Бие лүгээ сүүдэр мэт сахиул
Сайн чуулган өөрөө бүтэх
Сайн шидийг хайрлан соёрх*

хэмээн дэлхийн эзэн, нөхөр сэлтүүд өдөрт харуул, шөнөд манаа мэт сахиж нөхөр болон зохиогоод, гай барчад, газрын үүдийг үл хүсэмжлэн, хямран тэмцэх хол ойрын хорлол, хэл ам, атаа жөвчөө тэргүүтэн үл зохилдохын зүг бүхнийг амарлиулан, хотол олны нас буян, цог учрал, хийморь лундаа дэлгэрч хүссэн хэрэг аяндаа бүтэхийн хүй их үйлсээ даатган өчин залбирч байна.

Зохиолын төгсгөлийн үгэнд «...хэмээн энэ мэт нэгэн хэрэгтэй гэж Халхын жүн вангийн хошуу²⁰-ны рабжам цорж Ёндонбал дурьдсанд Ёнзон ширээт агсан их харш Боднойд найруулвай» хэмээн хэний дуртгал хүсэлтээр, ямар хүн, хаана зохиосон талаарх мэдээллийг бичжээ. Цаг хугацаа, үзсэн дуулсан багын эрхээр

²⁰ 1697 онд Тэрэлжийн Зуунмод хэмээх газар болсон тулалдаанд гавьяа байгуулсны тул засаг ноён Сэцэн хан Норовын хүү Илдэн засаг Пунсагт үе улируулан Илдэн жүн вангийн хэргэм зэрэг олгосноор үүнээс хойш Илдэн жүн вангийн хошуу хэмээн нэрийдэх болжээ. Пунцагийн дараа Найралт төвийн 13-р онд (1736) түүний хоёрдугаар хүү Чойжав, түүний дараа Чойжавын гуравдугаар хүү Дэмчиг, түүний дараа Дэмчигийн ахмад хүү Цэвээндорж, түүний дараа Тэнгэрийн тэтгэсний 46-р онд (1781) Цэвээндоржийн хоёрдугаар хүү Санжаадорж, түүний дараа Сайшаалт Ерөөлтийн 6-р онд (1801) Санжаадоржийн ахмад хүү Бат-Очир, түүний дараа Төр гэрэлтийн тэргүүн онд (1821) Бат-Очирын ахмад хүү Тогтохтөр (1797-1868), түүний дараа Бүрэн засагчийн 7-р онд (1868) То вангийн ахмад хүү Манзбазар, түүний дараа Бадаргуулт төрийн 10-р онд (1884) Манзбазарын ахмад хүү Доржпалам нар Илдэн вангийн хошууны засаг төрийн жүн вангаар үе улиран сууж иржээ [Гаваа, 2009: 17-20].

дуртгагч, зохиогч, зохиогдсон газрын талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулж эс завдсанаа хүлцэл эрье.

Монголчуудын уул ус шүтэх уламжлал нь дээд ертөнц тэнгэр, доод ертөнц лус хоёрыг эгцээр нь дунд ертөнц хүмүүн лугаа холбож үзэх үзэл санааг илэрхийлдэг бөгөөд өвгөд дээдсийнхээ авшиглаж шүншиглэж ирсэн уул усандаа амь нас, мал сүргээ даатган тахин шүтэж ирснээс юу санасан есөн хүсэл минь биеллээ олов хэмээн омогшин баясдаг ажээ. Тэрхүү тахин шүтэж ирсэн уул ус нь өөр өөрийн эзэнтэй, лус савдагтай гэж үзээд сан тахилын ном судар бүтээлгэж уншуулдаг нь газар газар ойролцоо байна [Сүхбаатар, 2001: 22].

Цагаан уулын сангийн судрын хувьд хэл найруулга нь яруу сайхан, дүр дүрслэл нь уран төгөлдөр, өгүүлэмж зохиомж нь баялаг дэлгэр бөгөөд агуулгаар нь авч үзвэл уул овооныхоо эзэн савдагийг үгийн шидээр аргадан, эдийн дээдээр тахин баясгаж, тэндээс нутаг хошуу, айл аймаг, гэр бүл, мал сүрэгтээ буян хишиг, аврал хайрлал гуйж буй аястай, нөгөө талаараа газар нутаг уул усаа онголон дархалж байгаль дэлхийгээ хамгаалах зорилготой зан үйлийн болон хүндэтгэл бишрэлийн нь илэрхийлэл болсон, Монголчуудын эрт дээр цагаас нутаг усаа эрхэмлэн дээдлэж, бишрэн тахиж ирсэн уламжлалт сэтгэлгээний онцлогийг тусгасан, Монголын уран зохиол дахь магтаал шүлгийн нэгэн хэлбэр гэж үзэж байна. Их утгач, профессор Л. Хүрэлбаатар багш ч «Магтаалын шүлгийн эртний уламжлал нь уул ус, газар лус, онгон шүтээнийг аргадан тахиж, түүний сүр хүчийг өгүүлэх бөө мөргөлийн яруу найргийн дуудлага тамлага, сан тахилгын зүйлд ашиглагдаж байсан бол буддын болон шарын шашны хожмын нөлөөллийн үед бурхан бодьсатва, тэнгэр нэрийг магтах, тахил өргөх, даатгал залбирлын зүйлсэд ихэд хэрэглэгдэх болжээ» хэмээн өгүүлсэн зэргийг үндэслэвэл Сангийн судар нь зөвхөн шашны зан үйлийг явуулахад унших ном төдий бус Монголын төвд хэлт утга зохиолд хамруулан авч үзвээс зохилтой яруу найргийн нэгэн төрөл зүйл хэмээн үзэж болно.

Номзүй

Аким Г., Баясгалан Т. нар. Монгол Улс дахь тахилгат газар нутаг / Ерөнхий редактор Н. Уртнасан. Улаанбаатар, 2009. 85 х.

Гаваа Б. Түүхэн цоморлиг. Улаанбаатар, 2009. 54 х.

[Зава Дамдин] 'dzam glin byang phogs chen po'i hor gyi rgyal khams kyi rtogs pa brjod pa'i bstan bcos chen po dpyod ldan mgu byed ngo mtshar gser gyi debt her zhes bya ba bzhugs so. 22a l.

Палам Б. Халхын Цагаан уул. Улаанбаатар, 2011. 106 х.

[Санжай]. sangs rgyas. bsang mchod bkri shis 'khyil ba. Хөхнуур, 1993. X. 123-124.

Сүхбаатар О. Монголын тахилгатай уул усны сангийн судар оршвой. Улаанбаатар, 2001. 22 х.

Сүхбаатар О. Вангийн цагаан уул // Халхын цагаан уул. Улаанбаатар, 2009. X. 31-34

Хишигтогтох Ц. Монголчуудын гал тахилгын түүхээс // Хэл зохиол судлал. Боть IV (36). Дэвтэр 1-22. Улаанбаатар, 2011. X. 126-142.

Хүрэлбаатар Л. Бичгийн болон ардын яруу найргийн зохиомж дахь таван хүслийн бэлгэдэл // Аман зохиол судлал. Т. XVII. Fasc 1-10. Улаанбаатар, 1987. X. 10-29.

Чоймаа Ш., Тэрбиш Л., Бүрнээ Д., Чулуунбаатар Л. Буддын шашин, соёлын тайлбар толь. Улаанбаатар, 1999. X. 201-202.

References

Akim G., Baiasgalan T. nar. Mongol Uls dakh' takhilgat gazar nutag / Erunkhii redaktor N. Urtnasan. Ulaanbaatar, 2009. 85 kh.

Gavaa B. Tuukhen tsomorlig. Ulaanbaatar, 2009. 54 kh.

[Zava Damdin] 'dzam glin byang phogs chen po'i hor gyi rgyal khams kyi rtogs pa brjod pa'i bstan bcos chen po dpyod ldan mgu byed ngo mtshar gser gyi debt her zhes bya ba bzhugs so. 22a l.

Palam B. Khalkhyn Tsagaan uul. Ulaanbaatar, 2011. 106 kh.

[Sanzhai]. sangs rgyas. bsang mchod bkri shis 'khyil ba. Khukhnuur, 1993. Kh. 123-124.

Sukhbaatar O. Mongolyn takhilgatai uul usny sangiin sudar orshvoi. Ulaanbaatar, 2001. 22 kh.

Sukhbaatar O. Vangiin tsagaan uul // Khalkhyn tsagaan uul. Ulaanbaatar, 2009. Kh. 31-34

Khishigtogtokh Ts. Mongolchuudyn gal takhilgyn tuukhees // Khel zokhiol sudlal. Bot' IV (36). Devter 1-22. Ulaanbaatar, 2011. Kh. 126-142.

Khurelbaatar L. Bichgiin болон ардын iaruu nairgiin zokhiomzh dakh' tavan khusliin belgedel // Aman zokhiol sudlal. Т. XVII. Fasc 1-10. Ulaanbaatar, 1987. Kh. 10-29.

Choimaa Sh., Terbish L., Burnee D., Chuluunbaatar L. Buddyn shashin, soelyn tailbar tol'. Ulaanbaatar, 1999. Kh. 201-202.

	<p>༭༭༭ ཚེ་ཀུའང་ཨ་ཀྱོལ་བསངས་མཚོན་བཞུགས་སོ། </p>	
--	---	--

<p>༭༭༭ ཨོ་སློབ་བཟང་བྱུབ་དབང་དོ་རྩེ་འཆང་ཆེན་སོགས། རྩ་བརྒྱད་སློབ་ལི་དམ་དཀོན་མཚོག་གསུམ། ལམ་ལུ་འགྲོ་ཚོས་སློབ་དྲུང་སློབ་བདེན་པའི་མཐུས། དེང་འདིར་དགོ་ལེགས་འདོད་དགུའི་ཆར་ཆེན་སོབ། ལམ་ལུ་འགྲོ་ལྱི་རྩུབ་བློགས་ལྷན་པོ་ཆེ། ཚེ་ཀུའང་ཨ་ཀྱོལ་ལི་སློབ་གནས་པའི། དགོ་བསྐྱེན་མི་དཀར་གསུལི་རལ་བ་ཅན། ལམས་གསུམ་དབང་འདུས་རྩུད་དམར་པོ་གལས། དགོས་འདོད་ཀྱན་འབྱུང་གཏོར་གྱི་ཞེ་ལེ་གཡོན། རྟེན་ཚོགས་དང་པུ་ཆེ་བས་ནས་ཡུལ་སློབ་བསྐྱུངས། ལ་ལོ་བསྐྱུང་བ་ཨ་ཙེ་སློབ་འདེད་སོགས། འཕོར་ཚོགས་དཔུང་དང་བཅས་པ་གནས་འདིར་བྱོན། པ་ཡང་འདུག་མཐུན་མོངས་ཚོགས་</p>	2
---	---

<p>༭༭༭ མཐུད་དང་། པ་ཡང་འདི་ལ་གེར་ཨོ་བ་ལ་སོགས་པའི། ཡུལ་འདིར་གནས་པའི་དྲེགས་པ་སྡེ་བརྒྱད་ཚོགས། དཀར་བློགས་ལྷ་སྲུ་གཞི་བདག་འཕོར་བཅས་རྣམས། ཐོགས་མེད་རྩུ་འཕུལ་བྱུགས་གྲིས་གནས་འདིར་བྱོན། མ་ཚོགས་ལྷན་གྲིས་བྱུབ་པའི་གནས་མཚོགས་འདིར། རིན་ཆེན་ལྷ་བཞོད་མངོས་པའི་གདན་ཁྲི་ལ། དགྲེས་པའི་འཕྲོམ་ཞལ་དང་བཅས་བཏན་པར་བཞུགས། དངོས་སུ་བཤམས་དང་ཡིད་ཀྱིས་སྐྱུལ་པ་ཡི། ཚོགས་དང་གཏོར་མ་མཐུན་པའི་དམ་ཇས་དང་། ར་སྐད་འོ་སྐད་སྐྱེན་སྐད་དང་སྐྱུང་བས། འདོད་ཡོན་ལྷ་ལྷན་གསེར་སྐྱེམས་བྱ་མཚོ་འདི། གཞི་བདག་དགོ་བསྐྱེན་ཆེན་པོ་འཕོར་</p>	3
---	---

	<p>བཅས་མཚོད། དཀར་ཕྱོགས་ལྷ་ལྷ་གཞི་བདག་ལམོར་བཅས་མཚོད། མཚོད་པའི་ཚོགས་འདིས་དབང་ བོ་རྒྱས་གྲུང་སྟེ། བདག་སོགས་བསམ་པའི་དོན་ཀུན་གྲུབ་པར་མཛོད། དྲི་ཞེས་སྐྱོས་སྐྱ་ས་འཛིན་སྟོང་ ལྷག་ཚོགས། བསྐྱེད་པའི་དྲུག་སྟེང་ནམ་མཁའི་ཁམས་གང་པའི། གཞི་བདག་དགེ་བསྐྱེན་ཚེན་པོ་ ལམོར་བཅས་བསངས། དཀར་ཕྱོགས་ལྷ་ལྷ་གཞི་བདག་ལམོར་བཅས་བསངས། བསང་འདིས་ཉམས་ ཚགས་ཅི་བཅིས་དག་གྲུང་ཅིག ། ལྷ་ཕྱོག་བཀའ་ཚད་ལ་སོགས་ཞི་བ་དང་། རྟོ་ཡོར་རྒྱུ་དོག་མ་ མཛོད་པར། འདོད་དོན་ཡིད་བཞིན་འགྲུབ་པའི་འཕྲིན་ལས་མཛོད། ལྷལ་འདིའི་གཞི་བདག་གཉེན་པོ་</p>	4
--	---	---

ལྷ་ལྷ་	<p>༄༅། ལམོར་བཅས་ཀྱིས། འདོད་ཡོན་སྐྱ་ལྷའི་མཚོད་པ་འདི་བཞེས་ལ། སངས་རྒྱལ་བསྐྱབ་པ་རྒྱས་ པའི་འཕྲིན་ལས་མཛོད། ལྷལ་འདིའི་གཞི་བདག་གཉེན་པོ་ལམོར་བཅས་རྣམས། དཀར་ཕྱོགས་བསྐྱུང་ མའི་དོ་བོར་མངའ་གསོལ་ལོ། ལ་རོལ་དག་སྟེའི་དབང་ཚོགས་འཛོམས་པ་དང་། སེ་བ་དོན་དང་རྩོན་ པའི་འཕྲིན་ལས་མཛོད། གཞེས་སྤྱ་བཀའ་ཤིས་ཚོ་རིང་འབྱོར་བ་རྒྱས། བྱིས་སྤྱ་ལམ་སྤན་ཚུ་ལས་བསྐྱེད་ འདོན་མཛོད། འཛིར་སང་དག་ཇག་ཚོས་རྒྱན་འཚོབ་བསྐྱུང་། མདོར་ན་བསམ་དོན་ཡིད་བཞིན་འགྲུབ་ པར་མཛོད། གཞི་བདག་དགེ་བསྐྱེན་ཚེན་པོ་ལམོར་བཅས་རྣམས། རོར་ལྷ་གཉེར་བདག་པོ་བོར་མངའ་</p>	5
--------	---	---

	<p>གསོལ་ལོ། རིན་ཚེན་འགྲུལ་རྒྱས་པའི་དངོས་གྲུབ་སྟོལ། རིགས་བརྒྱུད་ཚོས་སྲིད་རྒྱས་པའི་དངོས་ གྲུབ་སྟོལ། རྒྱལ་ཡིད་སྐྱ་བདུན་བཀའ་ཤིས་རྗེས་རྟགས་བརྒྱུད། རྟ་གཡག་རྩ་མོར་ར་ལྷག་འདོད་འཛོའི་ བ། ། གོ་བྱེད་མཚོན་ཆ་དཔལ་པོ་དཔལ་མོ་རྒྱན། སི་རབ་སྤྱིར་བཞི་ཉེ་རྒྱ་དཔག་བསམ་ཤིང་། རྫོང་ བརྒྱུད་སྤོང་ཚོགས་ཐམས་ཅད་གཡང་དུ་ལྷག། ལྷལ་འདིའི་རང་བྱུང་སྤྱི་རྣམས་འདུལ་བྱིས་སྤྱི་དག། བྱིས་པ་ རྣམས་ཀྱང་ལ་རབས་སྟོང་པས་ཚེ། རྗེ་དཔོན་རྣམས་ཀྱིས་ལམོར་འབངས་ཚོས་བཞིན་སྟོངས། ལུན་ ཚོགས་དཔལ་ལ་རྟག་ཏུ་རོལ་བར་མཛོད། མདོར་ན་གཞི་བདག་གཉེན་པོ་ལམོར་བཅས་ཀྱིས། ཉིན་གྱི་</p>	6
--	---	---

པ
ལྷོ་

༄༅། །བྱ་ར་མཚན་གྱི་མེལ་ཚོ་སོགས། ། ལུས་དང་གི་བ་མ་བཞིན་དུ་བསྐྱེད་བ་དང་། ། ལེགས་ཚོགས་རྒྱན་
གྱིས་ལྷག་པ་ལེ་དངོས་གྲུབ་རྩུལ། ། །།

7